

JOURNAL OF MONGOLIAN STUDIES

モンゴル研究

No. 32

《研究ノート》

Д.Пагмадуламыг уран сайхны зохиол, бүтээлүүдэд хэрхэн дүрсэлж илэрхийлсэн бэ?

Д.Намдаг “Цаг төрийн үймээн” роман (1960) ба түүнээс сэдэвлэн хийсэн

“Төрийн сүлд өршөө” УСК (1994) -ний дүрүүдэд тулгуурлан авч үзэх нь

Т.Энэбиш

モンゴル秘史を読む会、その後

内田 敦之

《資料紹介》

1930年代にブリヤートで出版されたモンゴル文字の書物 サイン・ホビト

歴史家 E. チメッドツェレンが D. パゲマドラムを解放した記述

—1973年に発行された『モンゴル人民共和国における女性を社会的抑圧から

解放した歴史的経験』を読む—

今岡 良子

《翻訳》

Д. Навцагдорж 「インドの踊り子に捧ぐ」

(訳) 織田 幸彦

Д. Навцагдорж 「世界の三大奇跡」

(訳) 織田 幸彦

《雑感》

1984年、モンゴル社会のラフスケッチ —家族を中心に、講義ノートから—

吉本 るり子

《活動報告》

活動報告 (2022年～2023年)

今岡 良子

モンゴル研究会

大阪
2023

目 次

2023 年

『モンゴル研究』第 32 号

《 研究ノート 》

Д.Пагмадуламыг уран сайхны зохиол, бүтээлүүдэд хэрхэн дүрсэлж илэрхийлсэн бэ?

Д.Намдаг “Цаг төрийн үймээн” роман (1960) ба түүнээс сэдэвлэн хийсэн “Төрийн
сүлд өршөө” УСК (1994) -ний дүрүүдэд тулгуурлан авч үзэх нь

..... Т.Энэбиш..... 2

モンゴル秘史を読む会、その後 内 田 敦 之..... 21

《 資料紹介 》

1930 年代にブリヤートで出版されたモンゴル文字の書物 サイン・ホビト..... 31

歴史家 E. チメッドツェレンが D. パグマドラムを解放した記述

— 1973 年に発行された『モンゴル人民共和国における女性を社会的抑圧から解放した

歴史的経験』を読む —..... 今 岡 良 子..... 50

《 翻 訳 》

Д. Навцагдолж 「インドの踊り子に捧ぐ」..... (訳) 織 田 幸 彦..... 75

Д. Навцагдолж 「世界の三大奇跡」..... (訳) 織 田 幸 彦..... 76

《 雑 感 》

1984 年、モンゴル社会のラフスケッチ

— 家族を中心に、講義ノートから —..... 吉 本 るり子..... 78

《 活動報告 》

活動報告 (2022 年～ 2023 年)..... 今 岡 良 子..... 112

Д.Пагмадуламыг уран сайхны зохиол, бүтээлүүдэд хэрхэн дүрсэлж илэрхийлсэн бэ? Д.Намдаг “Цаг төрийн үймээн” роман (1960) ба түүнээс сэдэвлэн хийсэн “Төрийн сүлд өршөө” УСК (1994) -ний дүрүүдэд тулгуурлан авч үзэх нь

Т.Энэбиш

Эхлэл

Д.Намдаг зохиолч Д.Пагмадуламыг төсөөлж романыхаа гол дүр Оюундарь бүсгүйн дүрийг гаргасан гэгддэг¹⁾. Тэгвэл зохиолч Д.Пагмадуламыг хувь хүний хувьд хэн байсан бэ гэдэг талаас нь уран сайхны дүрд хэрхэн шингээж өгсөн байж болох вэ? Оюундарь болон Амарзаяа бүсгүйн дүрээс Д.Пагмадуламыг хэрхэн олж харах вэ?

Энэ өгүүллэгт Д.Намдагийн “Цаг төрийн үймээн” роман (энэ өгүүллэгт цаашид “роман” гэнэ) болон уг романаас сэдэвлэсэн бүтээсэн “Төрийн сүлд өршөө” уран сайхны кино (энэ өгүүллэгт цаашид “уран сайхны кино”)-г сонгон авч тэдгээр бүтээлүүд дэхь гол дүрийн бүсгүйчүүдийн дүрийг тодотгон авч үзнэ.

Д.Намдагийн “Цаг төрийн үймээн” роман (1960)-ыг сонгон авч үзэх 2 шалтгаантай.

Нэгдүгээрт, Д.Намдаг болон Д.Пагмадулам, Д.Нацагдорж нар хамт сурч, нэг цаг үед амьдарч байсны хувьд тэрээр Д.Пагмадуламын талаар сайн мэдэх хүний нэг юм. Д.Намдаг зохиолч өөрөө бас хэлмэгдэж шоронд хэд дахин орж байсан. Тухайн цаг үед Д.Пагмадулам, Д.Нацагдорж нарын талаар хэлж ярих нь цээртэй цэрвэдэг сэдэв байсан гэдэг²⁾. Тийм ч учраас тэдний талаар үнэн худал нь үл мэдэгдэх цуу яриа гарч харлуулж байхад үнэнийг мэдэж байх ёстой нөхөд нь үг хэлж чадахгүй нөхцөлд дарамттай байсан мэт. Гэсэн ч зохиолч Д.Намдаг шоронд байхдаа бичсэн гэгддэг, мөн түүнийг алдаршуулсан бүтээлийн нэг буюу “Цаг төрийн үймээн” романы гол дүрийн бүсгүй Оюундарийн дүрийг Д.Пагмадуламаар төсөөлж дүрслэн гаргасан тухай яригдах нь олонтаа. Өөрөөр хэлбэл, зохиолч өөрийн мэдэх Д.Пагмадуламыг зохиолынхоо баатрын дүрээр илэрхийлж түүний талаарх андуу ташаа мэдээллийг залруулахыг оролдсон юм биш байгаа гэж бодогдоно. Энэ романаас сэдэвлэн хожим 1994 онд С.Жаргалсайхны найруулгаар “Төрийн сүлд өршөө” уран сайхны киног бүтээжээ.

1) Д.Нямаа “Их Нацагдоржийн гэргий Пагмадуламын амьдрал, аж төрөл” ху.62 “Цаг төрийн үймээн”-ний Оюундарийн дүрийг “Пагмадулам” гэж төсөөлөхөд болохоор гэдэг нь бас ойлгогдлоо.

2) Д.Нямаа: Яагаад Пагмадуламыг нэг их ярихгүй байсан юм бэ гэдэг нь бас их гайхаш төрүүлдэг. Пагмадуламд одоо дургүйдээ биш баймаар. Мэдэхгүйдээ бичихгүй байна гэж хэлэхэд хаашаа юм. Мэдэх улсууд эднийг судлаж бичиж байхад зөндөө байсан. Намдаг гуай, Намнадорж гуай, Наваан-Юндэн гуай гээд л. Тэгэхээр зэрэг би Ренчин гуай ингэж дурсаад байхад эд нарт дурсах юм их байх ёстой доо гэж боддог юм. “Бүрхэг шөнийн тэргэл саран” нэвтрүүлэгийн хэсгээс

Хоёрдугаарт, роман болон уран сайхны кинонд гол дүрийн бүсгүй “Богтлох ёс”-ны хохирогч болж дуусч байгаагаар үйл явдал өрнөдөг. Гол дүрийн бүсгүйн эх загвар болсон Д.Пагмадулам ч мөн 14 настайдаа богтлогдож айлын эхнэр болж байсан. Тэр туршлага нь түүнийг эмэгтэйчүүдийн эрх чөлөө, хөгжлийн талаар тэмцэх сэдэл нь болсон байх талтай.

Энэ судалгааны өгүүллэгт роман болон уран сайхны кинонд дүрслэгдсэн гол дүрийн бүсгүйн дүрслэлийн онцлог, Д.Пагмадуламтай ижил төстэй талыг тодруулахыг зорьлоо.

Ингэхдээ Д.Пагмадуламын өссөн төрсөн орчин, гэр бүл, гарал угсаа, эрдэм мэдлэг, бие авч явж буй байдал, зан ааш зэрэг хувь хүн талаас нь илэрхийлсэн дурсамж яриа, бичвэрийг ашиглан уран сайхны дүртэй харьцуулах замаар тодруулахыг хичээлээ.

Уг өгүүллэгийн агуулгыг 3 хэсэгт хуваан авч үзэх бөгөөд 1-р хэсэгт Д.Намдаг зохиолчийн товч намтар болон Д.Пагмадуламтай ямар холбоо харилцаатай байсан талаар дурдахын зэрэгцээ роман, уран сайхны киноны товч агуулга, үйл явдлыг тоймлон харуулна. 2-р хэсэгт Д.Пагмадуламын талаар түүнтэй нэг цаг үед амьдарч байсан хүмүүсийн дурсамж тэмдэглэл болон түүний талаар судалж тодруулж бичсэн судлаач, зохиолчдын бичвэрийг эмхэтгэнэ. 3-р хэсэгт энэ бүгд дээр тулгуурлан роман болон уран сайхны кино дахь гол дүрийн бүсгүйчүүдийн дүрийг Д.Пагмадуламын талаар дурсамж, тэмдэглэлийн агуулгатай харьцуулангаа ижил төстэй болон ялгаатай талыг тодруулна.

Нэг. Зохиолч Д.Намдагийн тухай, роман болон уран сайхны киноны үйл явдлын хураангуй

1.1 Д.Намдагийн амьдрал уран бүтээлийн тойм

Д.Намдаг бол Монголын орчин үеийн уран зохиолын гол төлөөлөгчдийн нэг бөгөөд жүжгийн зохиол, театрын урлагийн анхдагчдын нэг гэгддэг.

Тэрээр 1911 онд Сайн ноён хан аймгийн Үйзэн гүнгийн хошуу (одоогийн Завхан аймгийн Алдархаан сум)-нд өртөөч, улаач Донровын мэндэлсэн. 9 настай байхдаа нутагтаа бага сургуульд элсэн орж суралцаад, 14 настайдаа МХЗЭ-д элсэн эвлэлийн 4-р их хурлын төлөөлөгчөөр сонгогдон Улаанбаатарт ирсэн.

1926 онд 15 настайдаа Герман, Францад суралцах 35 залуусын нэгээр сонгогдон суралцахаар явсан. Тэдгээр залуусын дотор Д.Пагмадулам, Д.Нацагдорж нар байсан. Тэд хамтдаа Герман хэлний бэлтгэлд 1 жил суралцсаны дараа үргэлжлүүлэн Вихерсдорф сургуульд суралцаж байсан. Гэтэл 2 жилийн дараа буюу 1929 онд дуудагдан эх орондоо буцаж ирсэн байна. Ирээд дунд сургуульд багшаар ажиллахын зэрэгцээ Д.Нацагдоржтой хамтран “Учиртай гурван толгой” дуурийг найруулан тавьж хүмүүст хүргэж байжээ. Тэд бие биенийхээрээ орж гарч нөхөрлөдөг уран бүтээл болон амьдралын найзууд байсан аж.

Гэвч 1932 онд Д.Намдаг болон Д.Нацагдорж нар шинэ жил хамтдаа тэмдэглэсэнийг нь мушгин гуйвуулж “Манж-Го улс байгуулагдсаны 1 жилийн ойг тэмдэглэсэн” гэж гүтгэгдэн баривчлагдаж шоронд 1 жил хоригджээ. Энэ үеэс эхлэлтэй Д.Намдаг удаа дараа шоронд хоригдсон бөгөөд “Германы эсэргүүй тагнуулын идэвхтэй гишүүн байсан” гэхчилэн яллагдаж байжээ. 1941

оноос 1947 он хүртэл шоронд хоригдож гарч ирсэний дараа 1958 он хүртэл 10-аад жил сонгуулийн болон хэвлэн нийтлэх эрх хязгаарлагдмал байжээ. Гэсэн ч энэ хориг цуцлагдсаны дараахан буюу 1960 онд “Цаг төрийн үймээн” романаа бичиж гаргасан байна. Харин 1962-1964 оны хооронд Москвад М.Горькийн нэрэмжит утга зохиолын дээд сургуульд суралцжээ.

Зохиолч Д.Намдаг орчин үеийн утга зохиолын хөгжилд хувь нэмэр оруулах олон жүжгийн зохиол, уран бүтээл туурвисан ч 1930-аад оны хэлмэгдэл, хамт хэлмэгдэж байсан хүмүүсийн тухай, туулсан үзсэн харсан шоронгийн амьдрал зэргийг ил ярьж хэлэхээс цааргалдаг байсан гэдэг. Түүнээс энэ талаар асууж мэдэхийг хүссэн хүмүүс “шоронгоос гарч ирэхдээ ямар нэгэн зүйл ярихгүй гэж гарын үсэг зурж амлалт өгсөн” гэж ярьсаныг нь дурсжээ³⁾. Хэдий тийм боловч Д.Намдаг зохиолч “Цаг төрийн роман”-ны гол дүрийн бүсгүй Оюундарийн дүрийг гаргахдаа Д.Пагмадуламыг бодон бодон байж бичсэн гэж ярьж байжээ⁴⁾.

1.2 Д.Намдаг “Цаг төрийн үймээн” романы үйл явдлын тойм

Роман дахь Балданцэрэн гүн болон Оюундарь бүсгүйн хайр дурлалын үйл явдлыг харуулсан хэсгээс хураангуйлах нь:

Хүрээний Наймаа хотын нэгэн баян айл. Хүүхэд тогтохгүй байсаар ганц охинтой болсон. Түүнийгээ хайрлан хамгаалж гадуур хамаагүй гаргаж явуулахгүй, гэрт нь байлгах арга зам болгож бичиг үсэгт сургаж гэртээ ном уншиж сатааруулахыг зорьсон. Гадуур дотуур орж гарч гэрээс гардаггүй, гэр багшийнхаа хооронд л явж эрдэм номд шамдсан даруухан залуу бүсгүй. Бүсгүй номын багшийнхаа гэрт анх таарч танилцсан гүнд дурлаж бие биедээ хайр сэтгэлтэй болсон.

Гүн бүсгүйтэй хайр сэтгэлийн холбоотой болж ойр ойрхон уулздаг болсон ч бүсгүйн сүйх тэргээр гэртээ хүргүүлэх үед өөрийн ядуу бэл бэнчингүй байдлаас зовоод гэрээ худлаа зааж, өөр айлын гадаа үргэлж хүргүүлээд бууж үлддэг байв.

Хэдий бэл бэнчингүй ч төрд зүтгэж хэргэм цолоор шагнагдаж явсан тул Богдод хүсэлт гаргаж Богдын айлтгалаар хайртай бүсгүйгээ гэргийгээ болгохоор шийдэж хүсэлт гаргах боловч өөр хүний хүсэлт түүнийхээс өрсөж хайрт бүсгүйг нь богтлох лүндэн буудаг. Нөгөөтэйгүүр Хүрээ гамин цэргийн эзлэлтэнд орж төрийн зүтгэлтэн хүмүүсийг барьж хорих болов. Гүн ч энэ хомрогонд өртөж баривчлагдан шоронд оров. Энэ хооронд хайртай бүсгүйдээ хэл өгч чадахгүй, хайртай бүсгүйд нь Богдын лүндэн буусан тул танихгүй хүнд хүчээр богтлогдон эхнэр болохоор болов.

Бүсгүй хайртай хүндээ үүнийг хэлж хамт оргон зугтахыг хүссэн ч хайртай хүн нь шоронд орсон байсныг мэдээгүй. Гэр нь гэж бодоод уулзахаар очсон айл нь биш байсан. Тэр айлд нь очиход цөхөрч ядарсан хүүхэдтэй эмэгтэй байсан. Бүсгүй хайртай хүнийхээ нэрийг хэлж асууж сураглахад тэр айлын нөхрийн нэртэй ойролцоо дуудлагатай байж таарч, эхнэр нь нөхөрөө

3) Ч.Билигсайхан: Нацагдоржийн тухай сэдвээс, Нацагдоржийн амьдралын тухай сэдвээс, Пагмадуламын тухай сэдвээс ярих дуртай хүн нэг ч байгаагүй. Ямар нэг хэмжээгээр “Ярьж болохгүй ээ нөхдүүд” гэдэг. 10 жилийн шоронгийн дараа хэлж болохгүй юмны жагсаалтан дээр гарын үсэг зуруулсан гэдгийг Намдаг гуай надад ганцхан удаа хэлсэн. “Бид чинь ийм ийм юмаар ярьж болохгүй гээд гарын үсэг зурчихсан юм шүү дээ хүү минь” гэж. Энэ улсуудыг үхэхэд тэр хориг нь хэвээрээ л байсан юм чинь яаж тэр тухай ярих вэ дээ. “Бүрхэг шөнийн тэргэл саран” нэвтрүүлэгийн хэсгээс

4) Д.Нямаа “Их Нацагдоржийн гэргий Пагмадуламын амьдрал, аж төрөл” ху.39

араар тавьж гадуур зугаацаж явсан байна гэж эндүүрэн нөхөртөө гомдсон цөхөрсөн эмэгтэй учир начрыг олж тайлах сөхөөгүй хэдэрлэсэн нь Оюундарьт хайртай хүнээ гэр бүлтэй байж өөрт нь худлаа хэлж хуурчээ гэсэн сэтгэгдэл төрүүлсэн. Ингээд богтлогдохоос өөр гарцгүй, мөн нөгөөтэйгүүр итгэж найдаж байсан хайртай хүн нь өөрийг нь хуурлаа гэсэн бодолдоо хөтлөгдөн итгэж найдаж байсан бүхнээ алдсан нь түүнийг сонголтгүй байдалд оруулж эцэст нь хор ууж амиа хорлодог.

Гаминд эзлэгдсэн хүрээг цагаантаны цэргүүд чөлөөлж шоронд байсан хүмүүс суллагдахад гүн ч бас шоронгоос гарч ирэв. Гэвч түүнийг шоронд байх зуур хайртай бүсгүйд нь Богдын лүндэн бууж хүчээр богтлогдох болсноор амиа хорлосон дуулаад сэтгэлээр унаж цаг үеийн бурангуй ёсыг үзэн ядаж түүнийг халж солиход хүчин зүтгэхээр шийдэж хувьсгалын үйлст нэгдэн орж байгаагаар романы үйл явдал өндөрлөдөг.

1.3 “Төрийн сүлд өршөө” уран сайхны киноны үйл явдлын тойм

“Цаг төрийн үймээн” романаас сэдэвлэн бүтээсэн “Төрийн сүлд өршөө” уран сайхны кинон дахь Соном-Очир гүн болон Амарзаяа бүсгүйн хайр сэтгэлийн үйл явдлыг харуулсан хэсгээс хураангуйлах нь:

Хүрээний Наймаа хотын нэгэн баян айл. Тэднийх хоёр охинтой бөгөөд том охин нь Амарзаяа. Ээж нь охиноо эрдэм боловсролтой болгох гэж ойролцоох гудамжинд амьдардаг эрдэм номтой хүнд шавь оруулдаг. Аав нь панз наймаанаас өөр зүйлд ач холбогдол өгдөггүй гүйлгээ ухаантай сэргэлэн эр. Нэгэн өдөр Амарзаяа бүсгүй багшийндаа заалгасан шүлэг, үлгэрээ ярьж шалгуулж байх үед Соном-Очир гүн зочлон ирсэнээр тэд анх танилцдаг. Амарзаяа бүсгүй чин сүсэгтэй, цэвэр ичимтгий, эрдэм номд шамдсан, аав ээжийнхээ үгнээс зөрдөггүй даруухан бүсгүй.

Соном-Очир бол Богд хаант автономит засгийн газрын гадаад явдлын яаманд түшмэл хийдэг ажилдаа үнэнч зүтгэлтэй шударга идэр эр. Багадаа эцэг эхээс өнчрөн хоцорч Амарзаяагийн багшид 15 наснаас шавилан орж бичиг үсэг, түүх шашдир, төрийн бодлогын талаар заалган чиглүүлж тэр ачаар төрийн албанд зүтгэх болсон. Гэвч үнэнчээр зүтгэж ирсэн төр нь харийнханы гарт орж албанаасаа чөлөөлөгдөх болсноор улс орныхоо ирээдүйд сэтгэл зовохын хажуугаар цаашид яавал зохих талаар сэтгэлээ чилээж гарц хайж эхлэнэ. Ингэх зуураа ажлаа өгсөний дараа хэсэг хугацаанд уулзаагүй удсан багш дээрээ ирсэнээр Амарзаяа бүсгүйг олж харан сэтгэл татагдана.

Соном-Очир гүн, Амарзаяа бүсгүй хоёр анх багшийнхаа гэрт танилцсанаас хойш байн байн багшийндаа тааралдаж, тэгэх бүрт ойртон дотноссоор бие биедаа татагдана дурлана. Нөгөөтэйгүүр гүн улс орны ирээдүйд сэтгэл зовниж Жалханз хутагт, Дилав хутагт, Богд хаантай зөвлөлдөн тусгаар тогтнолоо эргээн сэргэхэд туслах гадны улсуудыг эрж хайн, холбоо тогтоохыг оролдоно.

Ингэж байх зуур Амарзаяа бүсгүйн аав нь өөрөө сонгож шийдсэн хүнтэй охиноо гэрлүүлэхээр тохиролцоно. Харин гүн Америк болон Орос гэх мэт улсуудаас тусламж эрэлхийлж байгаа талаар хүрээнд дэхь хятад цэргийн удирдлагуудад мэдээлэл очсоноос түүнийг гэрээс нь

гэнэт баривчлан шоронд хийж эрүүдэн шүүдэг. Сэтгэлтэй бүсгүйдээ ч хэл дуулгаж амждаггүй.

Энэ хооронд Амарзаяа бүсгүй хүчээр хүнтэй гэрлүүлэх болсонд дургүйцэж аав ээжээсээ битгий гэрүүлээч гэж гуйж хүссэн ч талаар болов. Ингээд хүчинд автаж танихгүй хүнтэй дэр нэгтгэсэндээ гутарч харамсан, нөгөөтэйгүүр сэтгэлтэй хүн нь хаачсан нь мэдэгдэхгүй хэл сураггүй болсонд бүсгүй байж ядан гүнгийн гэрт нь явж очно. Очтол хашаанд нь нэгэн бүсгүй гүнгийн хурган дээлийг салхинд сэврээгээд зогсож байхтай таарч мэнд мэдэнгээ гүнг сураглахад тоймтой хариу хэлсэнгүй. Гэтэл гүнгийн дээлнээс түүнд өөрийн гараар урлаж хийж бэлэглэсэн даалин унан газарт хэвтэж байхыг харав. Ингээд сэтгэл нь хоосорч тэндээс гэртээ буцаж ирдэг.

Удалгүй цагаан сар болж Амарзаяагийн хашаанд золголт болж байна. Гэтэл гадаа хашааных нь хаалга дуугаран хэн нэгэн яарч сандран тусламж эрэхийг сонсоод хамгийн түрүүнд Амарзаяа бүсгүй гүйн гартал танил данжаад өвгөн араас нь хөөж буй цагаантаны цэргээс зугтаж амь хорогдохоор орж ирсэн нь тэр байв. Амарзаяа бүсгүй өвгөнийг илүү гэртээ оруулж нуусан боловч араас нь хөөн орж ирсэн цэргүүд өвгөнийг олж чирэн гаргаж ирэхэд цэргийг дагуулж яваа залуу монгол эр өвгөн хятадыг буудахаар буу чиглүүлнэ. Энэ үед Амарзаяа бүсгүй амжиж өвгөний урдуур орж биеэр халхлан өөрөө бууны суманд оногдон нас бардаг.

Гэтэл бүсгүйг буудсан монгол эр шоронд хоригдсон Соном-Очир тэргүүтэй хүмүүсийг суллан гаргаж, гүн зодуурын шархтай амь нь дээсэн дөрөөн дээр байхад гэртээ авчиран аав дүүгээрээ асруулан тэнхрүүлдэг. Тэд айл хөрш бөгөөд дүү бүсгүй нь гүнгийн гэрт агаар салхи оруулан дээл бүсийг нь салхинд сэврээж байх үед нь Амарзаяа бүсгүй гүнг хайж уулзахаар ирсэн нь тэр байж.

Гүн шоронгоос гараад бие нь тэнхэрч сайжраад сэтгэлтэй бүсгүй Амарзаяагийн уулзахаар ирээд юу болсоныг мэдэж цочирдож гашууддаг. Ингээд тэрээр улс орны ирээдүйд сэтгэл чилээхдээ шулуудаж байгаагаар үйл явдал дуусдаг.

Хоёр. Д.Пагмадуламын талаарх хүмүүсийн дурсамж, баримт, тэмдэглэлийн тойм

2.1 Өссөн орчин, гэр бүл, гарал угсаа:

Пагмадулам Маймаа хотын уугуул оршин суугч гэдэг нь тэр үеийг мэдэх олон хүний яриа дурсамжаар хөдөлбөргүй батлагджээ. Манжийн хүрээ болж анх үүссэн багавтар хотыг хятадууд “Маймаа-чин” буюу худалдааны хот гэж нэрлсэн нь яваандаа сунжирсаар “Наймаа хот” болон нэршжээ⁵⁾.

Мужаан хэмээгдэх Дамдин. Богд Хаант Монгол Улсын гутгаар зэргийн тайж. Хуучнаар Сэцэн хан аймаг одоогоор Хэнтий аймгийн нутагт хамжлага албат олонтой. Эрт баатарлаг Чингис хааны өрлөг Хүлэг Боорчийн шууд удам тул зэрэг зиндаа дээгүүр, Амгаланбаатар хотод нэр нөлөөтэй, чинээлэг язгууртан байлаа⁶⁾. Тэрээр хоёр ч хүүхэд өргөж авсаны нэг нь Пагмадулам⁷⁾.

5) Д.Нямаа “Их Д.Нацагдоржийн гэргий Д.Пагмадуламын амьдрал, аж төрөл” ху.5

6) “Бүрхэг шөнийн тэргэл саран”

7) “Бүрхэг шөнийн тэргэл саран”

2.2 Зан ааш, биеэ авч явж буй байдал, эрдэм боловсрол

Наймаа хотын хүүхнүүд гоё дэгжин, дуу хуурт авьяастайгаараа Хүрээнд цуутай, Пагмадулам мариа тэгш цомхон бие, уян налархай хөдөлгөөнтэйн дээр нүд ам нь зурмал юм шиг цөм хэм хэмжээ зохицонгуй бөгөөд өнгөлөг тод, цаанаа л нэг эрүүл цул, бүлээн булбарайг илтгэсэн хөөрхөн цагаан хүүхэн байв⁸⁾.

Д.Нацагдоржтой танил, нэг хашаа хүрээнд сууж байсан гэгддэг С.Банзрагч 1973 онд “Утга зохиол, урлаг” сонинд өгсөн ярилцлагадаа Д.Пагмадуламыг “Цэвэрхэнээс цэвэрхэн хүүхэн байсан юм” гэж дурсжээ⁹⁾.

Д.Пагмадуламыг түүнтэй хамт Германд суралцаж байсан Н.Наваан-Юндэн дурсахдаа “Сувд шиг цагаан хүүхэн байж билээ” гэсэн бол бас нэгэн танил нь болох “Хар малгай” хочиг Жамбал гэгч хүн “Шанзаар хүрээ дуунууд их дардаг хүүхэн байсан. Жийжүү хот, Цэнхэрлэн харагдана, Янжуур тамхи дарж байсныг санаж байна” гэжээ. Мөн Шолоон Жамбалсүрэн гэдэг хүн “Хөөрхий дөө, сайхан ч бүсгүй, эрдэм номтой ч хүн байсан даа” гэх зэргээр таних мэдэх хүмүүс нь түүнийг эерэг аятайханаар дурсдаг байжээ¹⁰⁾.

Эрдэм боловсролын тухайд:

Ленинградд Д.Пагмадуламтай хамт суралцаж байсан Б.Ренчин тэр үеийг дурсахдаа “Тэр үед аль нэг сэдэв сонгож аваад шүлэг бичихэд зургаан хөвгүүнээс хоёр бүсгүй хождохгүй байсны нэг нь Пагмадулам” гэсэн байна. Тэрээр “Боржигон Нацагдорж” (1966) дурсамждаа “Нас залуу тэр үеийн монголтой хүний уншин мэдэх зүйлийг цөмийг шахуу гүйцээнээрээ, Ленинград хотноо суралцаж байсан хорин хэдэн монгол оюутны дунд дээгүүр суурь эзэлж, Нацагдоржийн дайтай түүх бичиг үзсэн хүн тэдгээр оюутны дотор дөрөв таваас илүү байгаагүйн дунд Нацагдоржийн гэргий Пагмадулам гэдэг эмэгтэй, уг нь Хүрээний Наймаа хотын унага, тэр монгол бичиг ном их үзсэн залуусын тоонд ордог байлаа” гэж дурсаад тийм болохын учир шалтгааныг хэлсэн байна. “Тэр бас аргагүй юм. Тэр үед Хүрээний Наймаа хотын залуучууд Нийслэл хүрээний залуучуудын дунд бичгийн боловсрол зэргээр тэргүүлж байсан” хэмээн тодосгожээ. Долоо хоногийн хагас сайны орой тийнхүү цуглаж элдвийг хэлэлцэхэд Пагмадулам ана мана оролцож байсныг Ринчен гуай дурсаад “Пагмадулам Наймаа хотын хүн болохоороо хятад ярианы хэлтэй. Эндээс аваачсан Санбуутай янжуур зуугаад, сэнгэнэсэн утаа баагиулан бидэнтэй уншсан түүх бичиг, Наймаа хотын хуучуулын зан заншил, инээдтэй ханиадтай юм ярьж суудаг сан” гэснээс үзвэл мэдлэг боловсролын хувьд нилээн дээгүүр үнэлэгддэг байсныг эндээс харж болно¹¹⁾.

2.3 Д.Пагмадуламын хайр дурлал, үнэнч сэтгэлийн талаар

1920 онд Пагмадулам Эрдэм Чин ван Паламын гэргий болон богтлогджээ¹²⁾. Гэвч жилийн

8) С.Эрдэнэ “Цэнхэрлэн харагдах уул” туужаас

9) Д.Нямаа “Их Д.Нацагдоржийн гэргий Д.Пагмадуламын амьдрал, аж төрөл” ху.34-35

10) Мөн тэнд ху.39

11) Д.Нямаа “Их Д.Нацагдоржийн гэргий Д.Пагмадуламын амьдрал, аж төрөл” ху.34-35

12) Богтлох ёс: 1925 оны 10-р сарын 30-ний Засгийн газрын тогтоолоор эмэгтэйчүүдийг богтлох ёсыг халсан.

дараа Ардын хувьсгал ялж Пагмадулам гэртээ буцаж ирсэн¹³⁾.

Пагмадуламын богтлогдож айлд эхнэр болон очсон талаар Наваан-Юндэн “Соёл эрдэнэ” /1974/ хэмээх намтар тууждаа дурдсан байна. Тэрээр өөрийн тухай бичихдээ бага залуудаа сур харваж яваад Эрдэнэ далай вангийн агь Балхжав гэгчтэй танилцсанаа тодорхой өгүүлжээ. Том биетэй ч тэнхээ тамир муутайхан гэгдэх Балхжавын урьсанаар нэг өдөр хамт сур харвах гэж гэрт нь очвол тэрбээр эхнэр авсан байжээ. “Цагаан дурдан дан дээл өмссөн цав цагаан царайтай тэр бүсгүй гартаа нэгэн дэвтэр барин сууж байв. Ямар нэгэн тайлбар толь шиг...санагдав. ...Балхжав ийм сайхан гэргийтэй болж гэж бодлоо. Дараа нь сонсвол эцэг ноён нь Богдод айлтган зарлиг буулгаж, тэндээс нэг өдөр хэдэн хаалгач давхиж очоод Пагмадуламыг жуузанд суулган Эрдэнэдалай вангийн дэргэд аваачиж өгчээ” хэмээн тодосгожээ. Мөн өдөр хашаан дотор тэднийг сур харван бужигналдаж байх үед “Пагмадулам гартаа барьсан номыг зааны соён савх мэт нарийхан цагаан хуруугаар хааяа эргүүлэн харж, байшингийн хаалганы дэргэд тавьсан нэгэн сандал дээр дуугүй сууж байх нь ягаан эрэн галбингаа торонд орсон буюу гэмээр гунигтай харагдав” гэсэн байх юм¹⁴⁾.

Энэ туулсан зовлон бэрхшээл нь түүнийг эмэгтэйчүүдийн эрх чөлөө, хөгжлийн төлөө санаа тавьж биечлэн манлайлах болсныг түүний намын их хурал дээрх илтгэлээс харагдана. Монгол ардын намын эмэгтэй гишүүдийн өмнөөс Пагмадуламын хэлсэн үгнээс товчилбол “...Ардын засаг байгуулагдаад олон бүсгүйчүүдийг эрдэм соёлд боловсруулан эрх чөлөөг эдлүүлэн, эрэгтэй эмэгтэй хэмээн ялгаварлахгүй, болгон эртний бүдүүлэг суртлыг устгасны учир....хүрээ, хөдөөний олон бүсгүйчүүдэд нэгэн адил эрх чөлөөг эдлүүлэн эрдэм соёлд боловсруулан улсын хэрэгт хир чинээгээр зүтгэцгээхийг эрмэлзсэн саналыг туйлд хүргэхийг ихэд итгэж горилно...” (“Ардын эрх” сонин. 1924 оны 8-р сарын 19, №20)¹⁵⁾ гэжээ.

Д.Пагмадулам 1920-1921 онд Богдын зарлигаар ноёны хүүд богтлогдож яваад гэртээ буцаж ирсэний дараа 1922 оны үеэс Д.Нацагдоржтой танилцсан¹⁶⁾. Эцэг нь тийм ч нааштай хүлээж аваагүй талаар С.Эрдэнийн “Цэнхэрлэн харагдах уул” баримтат туужид гаргахдаа. “Пагмадулам эцгийн зан байдал, бодол санааг сайтар мэдэх тул Нацагдоржтой танилцсаныг нь лав таашаахгүй гэдгийг ойлгон...нууцаар уулзаж байхаар шийджээ. Мужаан Дамдин бол Нацагдоржийг өнөөх л засгийн шалдан зарц гэхээс цаашгүй нь лав” гэснээс аяндаа харагдах ажээ¹⁷⁾. Гэсэн ч тэрээр өөрийн сонголт, шийдвэрээр Д.Нацагдоржтой гэрлэсэн. Тэд цугтаа 1925-1926 онд Ленинград, 1926-1929 онд Германд суралцаж, 8 жил хамт амьдарсан ч 1931 онд гэр бүл салсан¹⁸⁾. Гэхдээ энэ салалт гэр бүлийн таарамжгүй байдлаас биш тухайн цаг үеийн нөхцөл байдлаас үүдэн аргагүй байдалд орж хайртай хүнийхээ төлөө хийхээс өөр аргагүй сонголт байсан бололтой. Энэ талаар Ч.Билигсайхан “Д.Пагмадулам хилс хэргээр шоронд хоригдож гарч ирээд Нацагдоржийнхоо найз

13) “Бүрхэг шөнийн тэргэл саран”

14) Д.Нямаа “Их Нацагдоржийн гэргий Пагмадуламын амьдрал, аж төрөл” ху.8-9

15) Монгол Ардын намын гуравдугаар их хурал, 1924 оны найм-есдүгээр сар, дэлгэрэнгүй тэмдэглэл, УБ 1966

16) Д.Нямаа “Их Нацагдоржийн гэргий Пагмадуламын амьдрал, аж төрөл” ху.39

17) Д.Нямаа “Их Нацагдоржийн гэргий Пагмадуламын амьдрал, аж төрөл” ху.42

18) Мөн тэнд ху.39

нөхдийг цуглуулаад “Энэ хүн хэзээ нэгэн цагт төр засагтаа зөв харагдах цаг ирэх биз, тэр цагт би энэ хүнд гай болно. Иймд нөхрөөсөө саллаа.Нацагдорж өндөр эрдэм боловсрол, авьяас билэгтэй хүн, түүнийг та нар хамгаалж туслаж байгаарай” гээд явжээ” гэсэн байна¹⁹⁾. Гэсэн ч түүний энэ шийдвэрийн талаар, мөн Д.Нацагдоржоос салаад хаашаа явсан талаар “Данжаадтай суусан”, “Хар тамхинд орсон” гэх зэрэг үнэн худал нь үл мэдэгдэх ам дамжсан цуу яриа дэгдэж өнөө хир нь сарниагүй л байгаа юм.

Гурав. Роман болон уран сайхны киноны гол дүрийн бүсгүйн дүрслэл

3.1 Оюундарь болон Амарзаяа бүсгүйн гарал угсаа, өссөн гэр бүл орчны талаарх дүрслэл

Хүрээний Наймаа хотод өссөн тухай

Романд гарч байгаагаар Оюундарь бүсгүй ном заалгахаар хүрээний зүүн захад байх Наймаа хотоос сүйх тэргээр долоо хоногт 3 удаа багшийндаа ирдэг. Үүнийг мэдсэн Балданцэрэн гүн бүсгүйг хайж олж уулзахаар Наймаа хотод ирж хотын байр байдлыг шинжин явж байгааг дүрслэхдээ:

Наймаа хотноо орж ирэхэд огтын мэдэхгүй гудамжууд дайралдана. Эндхийн орон байшин, хашаа хороо цөм хятад маяг, сүрхий дорвиллог, том том улиасууд ба усны шуудуунууд хүртэл байн, байн дайралдана. Гудамжаар яваа хүмүүсийн байдал бас өөр, хятад, монгол, манж гурвын дундаас бүрэлдсэн юм шиг үзэгдэнэ. Ерөнхийдөө энэ Наймаа хот, Хүрээг бодвол цэвэр үзэмжтэй ажээ. Ялангуяа эмэгтэйчүүд нь сүрхий царайлаг болоод өмсөж зүүснээрээ гайхалтай дэгжин байлаа. “Цаг төрийн үймээн” романы хэсгээс...ху.90-92

Гэр бүл, өссөн орчин нөхцөл

Оюундарь бүсгүйн аав ээж гэр бүлийн талаар дүрслэхдээ:

... Эцэг нь Балсанжав хэмээх жирийн нэгэн баян хүн Зан ааш амгалан тайван хүн, бага насандаа эцгийн шаардлагаар ном сурах гэж нилээд оролдсон боловч идэвх оролдлого муутай болоод гавьсангүй. Одоо ч гэсэн ном үзэхээр нүд нь эрээлжлэн, нойр нь хүрнэ. Иймээрээ Балсанжав ганц охиноо ном бичиг сургахын төлөө бодомгүй байвч урьдтай нь хоёр хүүхэд төрөн эндсэн учир Оюундарь дээр хөл хорин энхрийлсэн бөгөөд арван ес хүрээд гадагш гарах, бусад хүүхэд багачуудтай эрхлэн тоглох гэж тэмүүлээд болохгүй болоход нь ном бариулсан хориглож эхэлсэн ажээ. Ийнхүү бүр дээр цагаас хөл хорьсон нь одооч бараг хэвээр. Тусгайлан барьж суулгасан гэрт нь эцэг, эх, арын байшинд суудаг хятад тогооч, морь тэрэгний жолооч Түвшин энэ дөрвөөс өөр хүн ордоггүй байлаа. Балсанжавын бодлоор бол охин тун нялх, балчир хэвээр, том болох нь зайлшгүй ч гэсэн үүрд дэргэдээ харж суухын хүснэ. “Цаг төрийн үймээн” романы хэсгээс...хху.112

19) Мөн тэнд ху.55

Наймаа хотод бүсгүйг хайж ирсэн гүн түр дулаацахаар орсон ногооны жижиг мухлагт бүсгүйтэй таарна. Тэд танилуудын ёсоор уулзаж гүн бүсгүйг хашааных нь гадаа дагаж ирэх үед гэрийнх нь байр байдлыг дүрслэхдээ:

..Ийнхүү ярилцаж явахад Балданцэрэнд тун аятайхан байлаа. “Одоо гэр орны нь хаа байдгийг мэдье” гэсэн нэг эрмэлзлэл сэтгэлд нь эргэлдэнэ. Гэтэл эмэгтэй нарийн цагаан шавраар нягт шавсан өндөр хашаандаа ойртон ирснээ хөл нь удааширч: -Манайх энд гэв. -Аль хаалга вэ? гэхэд -Тэр гэж заав. Тэр нь гэвэл хятад маягийн хөх шавар вааран оройтой сүрхий дорвилог асарт хаалга байлаа. Эмэгтэй хаалгандаа ойртох тусмаа “Та эндээсээ буцаарай” гэх мэт хөл нь улмаар удааширав. -Чи гэртээ олуулаа суудаг уу? гэхэд -Үгүй ээ. Ганцаараа. Аав ээж хоёр маань тусгай гэрт суудаг гэв. -Үгүй би нэгэнт энд ирснийх ороод явбал яасан юм бэ? Эмэгтэй цочин толгой сэгсрэв. -Яагаад? гэхэд бүр сандран тунгалаг цагаан хацарт нь цус гүйн ягаарч: -Айж байна. Аав, ээж хоёр харчихна гэж чичирхийлсэн хоолойгоор шивнэн өгүүлэв. Хаалгаа аяарханаар түлхэн нээхэд нь шавар вааран оройтой хөх туйлуун урт байшин хашааны хойт талыг бүхэлд нь эзэлсэний урдтай их бага хоёр гэр үзэгдэнэ. Ер энэ айлын хашаа, байшин ба гэр орон цөм дорвилог, ордог онгойдог бүхэн руугаа хөх туйлуу шигтгэн зам тавьсан байх бөгөөд зүүнтэй нь байгаа морины пин боловч айлын орон сууц шиг шилэн цонхтой байгаагийг нь үзэхэд хир баргын ноёдынх ч ийм байдаггүй шүү дээ гэж бодогдоно. ...Гэвч эргэх замдаа ирээдүйд чухам юу болохыг эргэцүүлэн бодож үзэхэд юм ер амар биш “үзтэл ийм баян айл байх атлаа чи ганц хүүхэнтэй нь суухыг санаархах чинь юу вэ? сүй бэлэгт нь чи юугаа өх гээ вэ? найр хуримыг чи хэрхэн өнгөрүүлэх гээ вэ? хүн хирээрээ, тэмээ тэнгээрээ гэгчээр өөртөө тохирох доогуур юмтай айлын хүүхэнтэй суувал дээр биш үү?” гэж бодогдоно... “Цаг төрийн үймээн” романы хэсгээс...ху.93-94

Уран сайхны кинонд Соном-Очир гүн багшийнхаа гэрт анх Амарзаяа бүсгүйтэй таарч, түүнийг хичээлээ дуусгаад гэрээс гарч явсаны дараа багштайгаа бүсгүйн талаар сонирхон ярилцаж байгаагаар дүрсэлдэг. Үүнд:

Амарзаяаг гэрээс гарсаны дараа Сономцэрэн гүн багшаас нь “багшаа энэ бүсгүйнх танайхтай ойролцоо байдаг юм уу” гэж асуухад багш нь “тийм, урд гудманд байдаг юм” гээд хөөрөгнөөс хамрын тамхи хутган авна. Тэгсэнээ “эх нь номтой хүний охин байгаа юм даа, тэгээд намайг гуйсан ухаантай юм” гэхэд Сономцэрэн гүн “аан” гэж зөөлөн уулга алдав. Багш нь үргэлжлүүлээд “эцэг нь гэж нэг Ёндонжамц гэж хүн байдаг юм, хөдөө хот хоёрын хооронд наймаа гүйлгэсэн амьтан байгаа юм л даа” гэж хэлэв. “Төрийн сүлд өршөө” УСК, I-р бүлгийн хэсгээс

3.2 Оюундарь болон Амарзаяа бүсгүйн биеэ авч яваа байдал, эрдэм боловсрол, төлөвшил, хандлагын талаар

Гадаад үзэмж, биеэ авч яваа байдал

....Хаалга нээгдэн нэг эмэгтэй орж ирлээ. Түүний нас залуу, зүс царай гуа сайхан, өмссөн хувцас нь гойд дэгжин, баруун гартаа шударга хөгжим сугавчилж, зүүн дээрээ хөх торгон баринтагтай зузаан дэвтэр залсан бөгөөд, босго давангуутаа өвдөг нахис хийлгэн Жамъяанд сөгдөөд тэндээс хойш хандан зуухны нөгөө талд суух гэхэд нь Жамъяан: --Үгүй, хүүхээ энд суу! гэж өөрийнхөө дээд тал тийш газар заав. Хүүхэн: <жа> гэж дахин мэхэсхийгээд зуухны урдуур тойрон өнөөх заасан газарт нь сөхрөн суулаа. Жамъяанд энэ эмэгтэй онц эрхэмлэгддэгийг Балданцэрэн мэдэв. Эмэгтэй 4 номынхоо баринтагийг тайлан хэдэн дэвтэр гарган Жамъяанд дэвшүүлж байгаа нь үнэхээр гайхалтай байх бөгөөд анх суухдаа биеэ барин цомцойсноосоо хажуу тийш хэлбийн шударгаа хөглөв. --За эхэл дээ гэж Жамъяан гуайн хэлэхэд: хараагаа дээш болгон шударынхаа ишийг атгасан гар дээрээ тусган хэсэгхэн зуур бодсоноо дарж эхлэв. Цохих нь цэвэр, дан ян гэсэн тунгалаг авиа борооны анхны дуслууд шиг нэг нэгээрээ цууриатаж эхэлснээ цаашаагаа ширүүсэн хурдсав. Шударгын урт ишийн дагуу таиуулдасхийсэн бие нь уянгалах аяа даган хөдөлнө. Балданцэрэн эмэгтэйн нүүрийг эгцлэн ширтэхгүй байхыг хичээснээ өөрийн эрхгүй жолоо алдан эмэгтэйд харсан бөгөөд нүдэнд нь хацар дээрээ улаавтар туяатай дугуй цагаан царай, талбиун болоод тунгалаг хар нүд, ухаалаг байрын тэнгэр магнай ба хэзээ боловч уур хилэгнэлийн муухай үгс гарамгүй зузаавтар улаан уруул тусах бөгөөд цааш бас төрүүлэх үр хүүхэд юугаа эсэн мэндээр бойжуулахын бэлэг тэмдэг болсон цээжин биеийн нь урагш түрэн товойсон хоёр хэсэг уг биеий нь гуа сайхныг улмаар үзэсгэлэн төгөлдөр болгосон ажээ. "Цаг төрийн үймээн" романы хэсгээс...ху.35-40

Боловсрол, хүмүүжил

Романд Оюундарь бүсгүйг бичиг үсэг, шүлэг, зохиолыг Жамъяан гүнд шавилан заалгаж байгаагаар, харин шударга хөгжим цохиж хятадаар дуулахыг хоёр нүд нь сохор хятад хөгжимчинд шавь орж заалгаж байгаагаар дүрсэлжээ.

...Одоогоос таван жилийн өмнө Оюундарь арван дөрөвтэйдөө Наймаа хотын эрлэг хааны сүмийн өмнө сохрын дуулахыг анх үзээд түүн шиг дуулан хөгжимддөг болохыг хүссэн билээ. Хүүхэд бүр юмыг хөнгөн хялбараар боддог ёсоор шударга хөгжим худалдан авч оролдоод санаа сэтгэлийн зовлон эдэлэхэд нь эцэг нь сохор дуучид шавь оруулсан юм санжээ. Түүнээс хойш Оюундарьд сургасан нь ер бага биш, хэдийгээр багшийнхаа адил хэдэн арван том дэвтрийг аялан дуулж чадахгүй боловч дуу шүлэг, үлгэр найраглалыг дуулж чадна. Үсэг номыг нь Жамъяан гүнээр заалган нарийн нямбай судалсан учир хятад хэлэнд ч сайн болсон байна. Сохор дууч хэдийгээр өдөр шөнө хоёрыг ялгахгүй хүн боловч Оюундарийн хоолойны сайхан, гар хурууны нь хөнгөн гавишгай тогтоон цээжлэхий нь хосгүй, эд бүхнээс нь жирийн охин биш гэж үнэлэн чин сэтгэлээсээ хайрлана. "Цаг төрийн үймээн" романы хэсгээс ху.125-126

Уран сайхны кинонд Амарзаяа бүсгүй багшийнхаа гэрт цээжилсэн шүлгээ уншиж шалгуулж байх үед Соном-Очир гүн гаднаас орж ирдэг. Багш нь бие нь тааруу тан уугаад орондоо хэвтэж байсан тул гүнг ирсэнд олзуурхан бүсгүйгээс шүүлэг авч өгөхийг хүсдэг. Гүн багшийнхаа оронд бүсгүйгээр шүлэг уншуулан шүүлэг авч байх зуураа түүний мэдлэг чадвар, гоо үзэсгэлэнг анхааран ширтэж байгаагаар үйл явдал өрнөдөг.

Амарзаяа бүсгүй багшийнхаа орны өмнө суугаад “Нүгэл буян хоёр зөрөлдөж тогтох хирнээ нүд нүдээ харалгүй сөргөлдөж явах орчлонд Үхлийг мартан үйлийг минь тээсэн ээжий минь ээ” гэж шүлэглэн уншина. ... “Сэрэмж алдсан нэгэн ягшиг хилэнт эзний бошго зарлигаар сүр жавхлангаа бууруулан үзэсгэлэнт амрагаас жилээр хагацаад сэтгэлт тааламжит гүнжийн угаал ариутсан мөрний ойр”... гэж шүлэглэн уншихад Соном-очир түүнийг үе үе ширтсээр сонсоно. Аяндаа хараа салгаж чадахгүй болсон мэт бодлогширон ширтэнгээ анхааралтай сонсоно. Багш нь ч чагнаж хэвтэж байгаад алдалгүй уран яруу уншиж байгаад нь сэтгэл тэнийж орноосоо хагас өндийсхийгээд чагнана.” үүл уулын оргил налан наалдсаныг ажиг үзэв” гэж уншихад өвгөн багш нь нүүрэндээ инээмсэглэл тодруулж “сайн цээжилжээ охин минь”, “за Амарзаяа охин минь одоо харьдаа” гэж хэлэнгээ аахилан янцаглаж орон дээрээ өндийж суугаад үргэлжлүүлэн “дараа ирэхдээ үргэлжлэлийг нь хуулж бичээд цээжлээд ир” гээд ягаан торгонд баринтагласан баринтагтай судар номыг орны толгой дээрээс авч Амарзаяад өгөнгөө “май энэ номыг уншаарай” гээд өгөв. “Төрийн сүлд өршөө” УСК, 1-р бүлгийн хэсгээс

3.3 Оюундарь болон Амарзаяа бүсгүйн хайр дурлал, үнэнч сэтгэлийн талаар

Хайр дурлал

Романд Оюундарь бүсгүй дурлалт залуудаа хайр сэтгэлийнхээ бэлэгдэл болгож хөөрөгний даалин урлаж дээр нь утга учир бүхий дүрс, үгийг хатгамалаар хатгаж бэлэглэдэг. Тэр үйл явдлыг дүрслэхдээ:

...Өдий болтол Балданцэрэн, Оюундарийн үнэт сайхан юм бэлэглэснийг мэдээгүй байжээ. Тэргэнд явж байхдаа өвөрт ханцуйтай гараа зүтгүүлэн хийгээд даруй нүд анин унтахад нь чин сэтгэлээсээ энхрийлэн хайрлахаас өөр юу ч үгүй явсан байжээ. Одоо өвөрт нэг юм товойн доош даран байгааг гар оруулан барьж үзээд ихэд гайхан гарган үзлээ. Хамгийн тэргүүн дайлангийн нэгдүгээр нүүрийн үүл, үүлэн дээрх буга, согоо хоёр нүдэнд туссаныг хэлэх үү урлан хатгасанд нь нүд нь утга агуулгы нь гүнд сэтгэл хоёр зэрэг булаагдан, <Үхэвч сэхэвч чиний төлөө> гэдэг ариун бодлого бодогдуулна. Дараа нь хоёрдугаар нүүрийн <Хүсэл мөрөөдөл биелэхийн цагт гал голомж бадрана> гэж дөрвөлжин үсгээр хатгасныг үзэж арайхан гаргаж уншаад <юутай сайхан үг вэ?> гэж бахдан баярлахынхаа зэрэгцээгээр арайхийн гарган уншсаныхаа хувьд аягүй бол би түүнээсээ дутуу мэдлэгтэй байхнээ гэж сэтгэл зовлоо. “Цаг төрийн үймээн” роман ху.117-118

Уран сайхны кинонд Соном-Очир гүн, Амарзаяа бүсгүй хоёр багшийндаа танилцсанаас ойр ойрхон тааралдах болж улмаар дотносон бие биедээ татагддаг. Багш нь ч нас эцэслэхийн өмнө гүнд “Надаас хойш энэ охиныг харж хандаж яваарай” гэж захижээ. Тэдний болзож байгааг дүрслэхдээ:

Гүн, Амарзаяа хоёр болзохоор уулзав. Амарзаяа сүйх тэрэгтэй гүнг хүлээн зогсоно. Гүн тэргэнийхээ гадаа хүлээн зогсож буй Амарзаяаг чиглэн явж очив. Амарзаяа инээмслэглэн угтан авлаа. Хоёул гар гараа барилцан баяртай уулзан золгов. Тэргэн дотор суугаад бие биенээ ширтэн бүсгүй ичингүйрэн доош тонгойн жаргалтай явна. Хамтдаа улаан дэнлүү өлгөсөн данжаадын зур агчны газарт ирэв. Зурагаа авахуулах гэхэд Амарзаяа “Яах юм бэ, нас хорогддог гэсэн” гэхэд гүн өхөөрдөн шоолон инээв. Бүсгүй ичингүйрэн босож гарахад гүн араас нь инээсээр дагаж гарав. Тэд хятад уушын газарт хоол идэхээр орж ирсэн байна. Хятад дуу хөгжим дуугарч үзүүлбэр үзүүлнэ. Эргэн тойронд хоол идэж архинд халамцсан хүмүүс олон.

Гүнгийн хажуу хашааны залуу бүсгүй хашааны хаалгаар гарч ирэх үед гадна нь сүйх тэрэг зогсох бөгөөд гүн бууж Амарзаяатай дотночилон салах ёс хийж байгааг хараад гуниглангүй буцаж хашаа руугаа оров. Гүн Амарзаяаг үдэж өгөөд араас нь сэтгэл тэнүүн харсаар зогсоно. Хажуу хашааны залуу бүсгүй хаалганыхаа дотор талд хаалгаа түшин санаа алдан гунихран зогсоно.

Уул ус жигдэрч цэцэг ногоо халиурч хөхөө шувуу донгодсон байгалийн сайхан хөдөөд Соном-Очир гүн, Амарзаяа хоёр хос морь унан болзон явна. Морио идүүлэнгээ саатах зуур бүсгүй сэм гүнгийн эмээл дээр өөрөө шаглаж урласан даалингаа тавив. Гүн түүнийг хараад гартаа авч үзэнгээ бүсгүй рүү инээмсэглэн явж очив. Хоёул морио хөтлөн хамтдаа аажуухан алхан явна. “Төрийн сүлд өршөө” УСК-ийн 3-р бүлгийн хэсгээс...

“Богтлох ёс”-ны талаар

Романы үйл явдал өрнөн буй цаг үед охид бүсгүйчүүд айлын эхнэр болохдоо богтлогдон гэрлэх явдал түгээмэл байсныг дурддаг. Энэ талаар дүрслэхдээ:

... “Тэднийх хүүхнээ тийм хүнд богтлон өгчээ. Өнөөхөөс нь салгасан гэнэ. Гэтэл бас Богд эгээнтэн өөрөө нэг хоёр амрагийг зарлигаар салган эмэгтэйг нь тэр ноёны хүүд өгсөн гэдэг шүү” гэж ярихыг зүгээр сонирхол болгохын үүднээс биш, харин өнөө маргаашийн нэгэнд өөр дээрээ тусах гэж байгаа гай гамигийг үнэнхүү сэтгэлийнхээ амрагт мэдэгдэж байгаа нь тэр байлаа. Эдгээр дууны ая монгол орны уудам тал, алс тэртээд цэнхэрлэн сүүмэлзэх өндөр уулс, тэр уулсын зүг тэмүүлэн яваа морины хөнгөн алхалт буюу задгай хатиралтыг санагдуулах боловч үг өгүүлбэр нь даанч тийм бишээ. Эрх мэдэлгүйн эрхээр хайрт амрагаасаа хагацах гаслал зовлон эдлэхийг л илэрхийлнэ. Ингэхэд тэд одоо ийм аюулыг хүлээж байгаадаа энэ дуунуудыг дуулах дуртай байлаа. Өөрөөр хэлэхэд тэд, зүй ёсны найр наргиан болж байгаа биш зүрх сэтгэлийнхээ бачимдлыг харилцан хэлэлцэж байгаа нь энэ ажээ. Гэрээс хүмүүс гарч

гүйцсэний дараа Балданцэрэн ганцаараа гарав. Найр цэнгэлд оролцсоны хувьд санаа сэтгэл сэргэсэн юмгүй. Эр нөхөд ба тэдэнтэй чин сэтгэлээ холбосон ариун охидын эрх мэдэлгүйн уй гашиу нь сэтгэлд нь эргэлдэнэ. Гэтэл үүнд бас Богдын зүй бусын зарлиг мөн л холбогдолтой байх тул Балданцэрэн <Түмэн олонд эрх жаргалыг эдлэх хувь заяа хэзээ ч ирэхгүй нь!> гэж гутрана. “Цаг төрийн үймээн” романы хэсгээс ху.28-31

Сүйн инжинд өгөх эд хөрөнгөгүй, сэтгэлт бүсгүйгээ авч суухад бэл бэнчин хүрэхгүйдээ сэтгэлээ шаналгаж байсан гүн Богдоор айлтгал гаргуулахаар очдог.

....Сойвон: “Үгүй чи чухам ямар хишиг хүртэхийг хэлээд байна вэ? “гэж саваагүйхэн байдлаар инээмсэглэв. “Ай даа ламтан минь юу ч гэх вэ дээ? Ичин эмээхийг хойш тавин, болхи бүдүүлгээр хэлэхэд нэг биеий минь хоёр, нимгэн биеий минь зузаан болгож хайрлахыг л айлтган мөргөх гэсэн юм”. “За, за мэдлээ. Ханьтай болгож хайрлахыг л айлтгах гэсэн хэрэг”. “Тийм ламтаан. Гэвч хэн нэгнийг биш, хоёр сэтгэл харилцан тохирсон нэг эмэгтэй байгаа юм. Түүнтэй шууд суух гэхэд юу гэх юм бэ дээ” гээд хөрөнгө зoorьгүйгээ хэлэхээс зовнин түгдрэв. Гэтэл сойвон “За, за мэдлээ. Гэр орныхон нь болохгүй байгаа юм уу?” “Тийм” гэж Балданцэрэн яаран хариулав. Сойвон “хэ хэ” гэж инээн: “Бага хэрэг. Богд ламтан та хоёрт үггүй өршөөл хайрлана гэж мэд! Би ч ийм хэрэгт тус нэмэр болох дуртай. Эр, эм хоёрыг нийлүүлэх бол энэ насны нь хувь заяа, зам мөр хоёры нь олгон тэтгэх гэсэн үг. Ингэх юун муухай хэрэг байх билээ. Гэвч тэр бүрээрээ биш бий. Би тун саяхан мэдлээ. Зүүн аймгийн нэгэн ноён хүүгээ ханьтай болгох гэж нэг айлын охины нэр насыг тодорхойлон айлтгаж, зарлиг буулгуулж авлаа. Хүүгий нь үзвэл зүс царай, ухаан санаа аль ч талаараа базаалтай биш, бодвол цаад охин мэдээжийн хэрэг сүрхий сайхан амьтан байж таарна. Ингэхээр тэр хоёрыг нийлүүлэх нь тийм ч сайхан хэрэг биш болно доо. За тэгээд нэгэнтэй дээрхээс болгоон зарлиг буулгаснаас яая гэх вэ? би тэр зарлигийн бичгий нь хийх гэж сая бууж ирээд сэтгэл тавгүйтэн гар маань ч бийр янтай руу явж өхгүй шиг сууж байтал та орж ирэв шүү. Ингэхэд танай сэтгэл нийлсэн эмэгтэйтэйгээ ханилахыг хүсэж байгаа чинь маш сайхан байна”. “Цаг төрийн үймээн” романы хэсгээс ху.123-124

Гэтэл Балданцэрэн гүнтэй ярилцаж байх үед сойвон лам сэтгэл зовнин хэлж байсан зарлиг нь үнэндээ хайртай бүсгүйг нь хүчээр богтлож гэрлүүлэх зарлиг байдаг.

...Өнөөдөр Богдын зарлиг буух гэнэ. Соёг лам: ---Цэцэн хаан аймаг гэж намуухнаар эхлээд цааш шуурхайлан уншсан нь: ---Олон хушуу ноёдын нэгэн болох Нямцэвээний аги эдүүгээ нас хорин гурав, ханилан сууваас зохих хувь заяаны нь бүсгүй Наймаа хотын Балсанжав гэгчийн төрүүлсэн охин Оюундарь мөн учир Богд налам бийгээр зарлигаар нийлүүлэн суулгасугай! гээд за зарлигт мөргөцгөө гэв. Оюундарийн ухаан балартан харанхуйлав. Аав ээж хоёроо үгүй татгалзана байх гэж ажихад үг дуугүй мөргөн, соёг зарлигийн бичгээр адис тавьж байлаа. Дараа нь соёг Оюундарь руу инээмсэглэн адис тавихаар гар сунгахад нь муужран унасан ажээ. Нэг мэдэхэд өөрийнхөө суудаг гэрт хүргэгдэн ирсэн байх бөгөөд эх хажууд нь: “Эвий минь, хөөрхий минь одоо яая гэх вэ? Богдын зарлигийг хэн боловч давж болдоггүйгээс хойш яахын ч

арга алга” гэж илэн таалан уйлан суужээ. Ху.128-129

Оюундарь бүсгүй боглогдохын эсрэг өөрийнхөөрөө эсэргүүцэн тэмцэж байгаа дүрслэхдээ:

Оюундарь эхийнхээ <Богдын зарлигийг давж болдоггүй юм> гэж байн байн давтан хэлснийг чин сэтгэлээсээ жигшин, нэг ч үг дуугаралгүй байгаад гэрээсээ гаргасан ажээ. Өөрийн нь бодлоор бол: <Бид ганц охиноо бусдад өгөхгүй> гэхээс аваад <Өөрийн нь санал мэднэ> гэх хүртэл олон төрлийн шалтгаан байж болох шиг санагдана. Хэрэв тэр бүхнээрээ болдоггүй аваас намайг нэг тийш нь сэм оргон зугтаалгаж болох шүү дээ гэхээс эцэг эх хоёрыг өшин занх сэтгэл төрнө. “Одоогоос эхлээд надад аав ээж байхгүй, авран ивээх бурхан сахиус ч алга. Цөм Богдын талд байдгаар миний дайсан шүү дээ” гэхээс даруй боож үхүүштэй ажээ. Гэвч Балданцэрэнг бодлоо. Тэр маань надад чин сэтгэлээс хайртай болохоор намайг өмгөөлөн хамгаалах төдийгүй өөрийн биеэр аван, нэг тийш оргох болов уу гэх сэтгэл төрөхөд өөрийн эрхгүй баяр баясгалантай боллоо. Ху.129-130

Уран сайхны кинонд Амарзаяа бүсгүй найз эмэгтэйн хамт гэртээ гэрлэлтийн талаар ярилцан сууж байгааг дүрслэхдээ:

Амарзаяа найз бүсгүйтэйгээ гэртээ байна. Найз бүсгүй нь шанз дарж Амарзаяа юм хатгаж оёно. Амарзаяа: “Чи тэгээд тэр хүндээ очихоор бүр шийдээ юу?”, Найз бүсгүй: “Тиймээ”, Амарзаяа: “Аав ээж хоёр чинь өөр хүнтэй сүй тавьчихсан гээд байсан?”, Найз бүсгүй: “Би ч бүр сэтгэлгүй хүнтэй суухгүй гээд уйлаад л байсан. Тэгсэн дорвол үхсэн минь дээр”, Амарзаяа: “Та хоёр тэгээд хэзээ хуримаа хийх юм бэ?”, Найз бүсгүй: “Одоо Түвдэнгийн аав ээж хоёр ирэх юм гэнэ билээ. Тэгэхээр л өдөр судраа товлох байх даа”, Амарзаяа: “аан”, Найз бүсгүй: “Хүүе ээ, чамайг аав чинь хүнтэй суулгах гээд сүй тавьчихсан юм биш биз дээ?” гэхэд Амарзаяа: “Иймээ тиймээ юм ярьдаггүй ш дээ” гэв. Найз бүсгүй нь аальгүйтэн жогтой инээснээ: “Чи чинь арай баян луухааны эхнэр болох гэж байгаа юм биш биздээ аан” гээд жиг жиг хөхрөн сонжингүй харахад Амарзаяа эвгүйцсэнээ “чи арай ч дээ” гэж доош харав.

Амарзаяа найз бүсгүйтэйгээ гэртээ байна. Найз бүсгүй нь шанз дарж Амарзаяа юм хатгаж оёно. Амарзаяа: “Чи тэгээд тэр хүндээ очихоор бүр шийдээ юу?”, Найз бүсгүй: “Тиймээ”, Амарзаяа: “Аав ээж хоёр чинь өөр хүнтэй сүй тавьчихсан гээд байсан?”, Найз бүсгүй: “Би ч бүр сэтгэлгүй хүнтэй суухгүй гээд уйлаад л байсан. Тэгсэн дорвол үхсэн минь дээр”, Амарзаяа: “Та хоёр тэгээд хэзээ хуримаа хийх юм бэ?”, Найз бүсгүй: “Одоо Түвдэнгийн аав ээж хоёр ирэх юм гэнэ билээ. Тэгэхээр л өдөр судраа товлох байх даа”, Амарзаяа: “аан”, Найз бүсгүй: “Хүүе ээ, чамайг аав чинь хүнтэй суулгах гээд сүй тавьчихсан юм биш биз дээ?” гэхэд Амарзаяа: “Иймээ тиймээ юм ярьдаггүй ш дээ” гэв. Найз бүсгүй нь аальгүйтэн жогтой инээснээ: “Чи чинь арай баян луухааны эхнэр болох гэж байгаа юм биш биздээ аан” гээд жиг жиг хөхрөн сонжингүй харахад Амарзаяа эвгүйцсэнээ “чи арай ч дээ” гэж доош харав.

Найз: “Заа энэ чинь тоглож байхад чинь. Тоглосон юм байхгүй юу” гэж аргадангүй хэлэв.

“Төрийн сүлд өршөө” УСК-ны 3-р бүлгийн хэсгээс...

Гэвч удалгүй Амарзаяагийнхд худ ураг болохоор аавынх нь танил хадаг барин бүсгүйг бэр буулгахаар ирдэг.

Амарзаяагийн аавын гэр. Хадаг барьсан хүн “Зээ, тавиу сайхан танай өргөөний өргөн сайхан үүдийг тань нээж, өлзийт сайхан босгоор тань алхаллаа. Амраг хоёр хүүгийнхээ ашдын заяат буяныг ачлалт бурхандаа даатгаж алд цэнхэр хадгаа өргөн барьж аав ээж ахан дүүс бүгдээрээ худ ураг болцгооёо” гэж ерөөл хэлэн хадгаа өргөн барихад нь аав нь “заа” гээд гараа дэлгэн тосон авав. Энэ бүхнийг Амарзаяа гайхаж түгшсэн харцаар харан сууна.

...Ээж нь “үгүй чи чинь хоол унд ч идэхгүй ингэж яаж болох вэ дээ охин минь” гэхэд Амарзаяа “ээж минь би тэр танихгүй айлд чинь яаж очих юм бэ” гээд эргэн харж ээжээсээ царайчлан гуйж “ээжээ та ааваас гуйгаад өгөөч дээ” гэхэд ээж “за за охин минь ингэж болдоггүй юм” гэхэд Амарзаяа “Би тийшээ чинь яасан ч очихгүй” гээд ээжийнхээ өвөр дээр толгойгоо тавин хэнгэнүүлэн уйлав. Ээж нь “одоо яая гэхэв дээ охин минь” гээд үсийг нь илбэнэ. Амарзаяа “би яасан ч очихгүй ээ” гээд улам чангаар уйлахад ээж “яая гэхэв бүсгүй хүний заяа тавилан гэдэг чинь ийм л байдагаас хойш яая гэхэв дээ охин минь” гэж аргадана.

Ээж нь уйлан дуугарч “Ёндонжамц минь муу охиноо яадаг юм билээ. Цаадах чинь уйлаад л хэвтэнэ” гэхэд аав нь “За за уйллаа уйллаа гээд ямар үхэх юм биш яадаг юм. Ёстой юм ёсоороо л болж байна ингэдэг л жамтайгаас хойш одоо яая гэхэв”, “Жүгдэрнамжил гуай чинь хээээний мал хөрөнгө сайтай хүн. Уг хүн нь элдэв хорон санаа байхгүй тун сүрхий хүн. Тэгээд ч бид нар эртний танилууд. Хүү нь яггүй сэргэлэн сүрхий хүүхэд байгаа юм. Тэгээд л би дуртай байгаа юм шүү дээ. Уг нь ч дагуулаад сургаад авбал наймааны ухаанд ч муугүй болох янзтай шүү” “Ер нь ойрхон гэр хашиа төхөөрч өгөөд дэргэдээ байлгаюу гэж санаж байгаа юм” “яахав олон жил хуруу хумсаа хуйхалж явж жаал юм хураалаа. Би ямар мөнх байх биш дээ. Энэ муу хоёр охин чи бид хоёроос хойш хүний царай харахааргүй л явбал боллоо шүү дээ, тийм биз дээ” гэж эхнэрээ ятгана. Ээж нь “муу охиноо харахаар л гол харлаад байх юм. Охин минь өөр хүнд л сэтгэлтэй байсан юм болов уу даа” гэхэд аав нь “юу гэнэ ээ?” гэж зогтусхийж асуув. Ээж “яагаав Соном-Очир гүнтэн, талийгаач өвгөн багшийн шавь Соном-очир гүнтэн, тэднийхээр л орж гарч байж хоорондоо танилцсан юм байх аа даа” гэхэд аав нь ёозгүйхэн “Үгүй чи битгий дэмийрээд байгаач. Соном-Очир шүү. Бас гүн гэнээ” гэж дооглонгүй хэлсэнээ “тэр ч дээ эрээн цаас шагайхаас өөр идгүй амьтан байх. Тэгж ч чулуун жинснээс өөр гялайх юмгүй хүнд харин ч муу охиноо өгөхгүй шүү. Хөрөнгө хурааж үзээгүй хүн зарж мэддэггүй ээ гэдэг юм, за за тэр ч яахав” гээд үл тоосон шинж гаргаж орондоо орж хэвтэв. “Төрийн сүлд өршөө” УСК-ны 4-р бүлгийн хэсгээс

Хайр сэтгэлийн төлөөх сонголт ба золиос

Романд Оюундарь бүсгүй хүнд богтлогдох болсоноо хайртай хүндээ дуулгаж хамтдаа зугатахыг ятгахаар гэрт очихоор явж байх замдаа дотроо бодож байгаагаар дүрслэхдээ:

Оюундарь <Ер миний одоогийн амьдрал эгээ л энэ донсолгоо шиг болж дээ> гэж нэг үе бодсоноо: <Үүний өмнө би уй гашуугаар бууж өгөхийн оронд эрэмгий зоригоор тэмцэх ёстой> гэж биеэ ятгав. Үүнээс цааш бодохдоо, Балданцэрэнтэй уулзах, уулзсан хойноо бүх явдалаа нэгмөсөн тоочих, тэгээд хоёулаа оргон алга болохыг бодож, үүнээ Оюундарь сэтгэлчлэн бүтээхэд бат итгэн баярлах ажээ.

Гэвч Балданцэрэн шоронд орсныг мэдээгүй, өмнө нь гэрээ гэж зааж өгөөд хүргүүлдэг байсан хашаанд очтол хүүхэдтэй эмэгтэй нөхрийгөө гэж андууран буруу ойлголт төрүүлдэг. Оюундарь бүсгүйн сэтгэлийн зовиурыг дүрслэхдээ:

...Оюундарь нэг ч үг дуугарсангүй. Сэтгэлд нь зөвхөн “Намайг аврах юм юу ч алга” гэдэг бодол эргэлдэж байсан бөгөөд хөл нь тэндээс өөрөө хөдлөн гадагш гаргажээ. Оюундарь хэмжээгүй итгэсэн ганц горьдлогоо бүрмөсөн баларсны хувьд бүх тэнхэл нэгмөсөн алдарч, нүдээ ч чавчих сэхээгүй болсон байлаа. Яг энэ үеэр Оюундарьд, эрдээ хаягдсан хөөрхий эхнэр, түүний гунин гутрахад дарагдсан царай, хоёр нялх хүүхэд...юутай хүүтэйгээ сэтгэлд орж ирэн, нүдэнд нь тусах ажээ. Түүнийг Оюундарь өрөвдлөө. Түүнийг төлөөлөн Балданцэрэнг чин сэтгэлээсээ жигшин заналаа. Гэтэл тэр эмэгтэйн гунигт явдал ер хэн нэгэн хүний явдал биш, харин монгол эмэгтэй бүрийн хувь заяа мөн байх тул Оюундарь, “Над амьдрах ба амьд явахыг хүсэн амь биеэ хайрлахын хэрэг юу вэ?” гэдэг асуудлыг өөртөө тавив.

Уран сайхны кинонд ч мөн адил Амарзаяа бүсгүй богтлогдох болсоноо хайртай хүндээ хэлэхээр гэрт нь очсон үеийг дүрслэхдээ:

Гүнгийн хашаанд хажуу айлын бүсгүй гүнгийн хурган дотортой сэгсүүргэн дээлийг агаарт дэлгэж хэцэнд тохож тавьж буй үзэгдэл. Хажууд нь сүйх тэрэг нь буулганаасаа буулгаастай байна. Амарзаяа тэнд орж ирсэн байв. Дээлийг сэгсэрч тохох үед тэндээс Амарзаяагийн гүнд өгсөн даалин нь унаж ирсэнд тэрээр авч нандигнан энгэртээ наав. Амарзаяа: “Амар байна уу?” гэж мэндлэхэд бүсгүй “мэндээ, амар байна уу” гэж хариу мэндлэв. Амарзаяа: “Энэ Соном-Очир гүнтнийх мөн үү?” гэхэд бүсгүй “Мөн мөн, та яах гэсэн юм бэ?” гэж асуув. Амарзаяа: “Соном-Очир гуай бий юу?” гэхэд бүсгүй “Одоохондоо эзгүй байгаа” гэхэд Амарзаяа “хэзээ ирэх юм бол?” бүсгүй “Мөд ирэхгүй биздээ”, “Айлд ирсэн хүн байна даа, та гэрт орооч” гэхэд Амарзаяа “явья даа” “би уг нь...” гээд үгээ гүйцээж хэлж чадалгүй цааш эргэн гарч явав. Амарзаяа ганцаар гунигт дарагдан гудамгаар алхан явна. Гүнтэй хамт өнгөрүүлсэн үеэ эргэн дурсав. Гүн: ““аав, ээж тань өдий орой болтол хаагуур явав гэж загнавал яана?”, Амарзаяа: “үерхдэг хүүхнийд үлгэрч ирээд хуурдаж дуулсаар өдий боллоо гэвэл яах бол” гэж ярилцаж байснаа дурсан санав. “Төрийн сүлд өршөө” УСК-ны 4-р бүлгийн хэсгээс...

Ингээд Амарзаяа бүсгүй аавынхаа танилын хүүтэй хүчээр дэр нэгтгэсэндээ харуусан, мөн хайртай хүн нь хаачсан нь мэдэгдэхгүй алга байгаад гуниж цөхрөн эцэст нь амиа алдаж байгаагаар дуусдаг.

Ёндонцамжынд золголт үргэлжилсээр. Гэтэл гадаа буун дуун гарав. “Юу болж байна. Шинийн нэгэнд буу дуугардаг чинь юу болж байна”, “Ээ төрийн минь сүлд”, “Энэ нэг л ёозгүй юм боллоо шүү” гэж гэр доторх хүмүүс ам амандаа хэлнэ. Амарзаяа түрүүлэн гэрээс гарч иртэл хашааны хаалгаар данжаад сандран гүйж орж ирэв. Луухан “Амарзаяа намайг нуугаад өгөөч сүйд боллоо” гэсээр амь тэмцэхэд нь бүсгүй түүнийг хойд гэртээ оруулав. Араас нь хашаанд буу агссан Ананд тэргүүтэй цагааны цэрэг дагуулсан морьтой хүмүүс дайран орж ирээд “ийшээ орсон луухаан хаана байна” гэж асууж зандрав. “Алив тэр илүү гэрт нь орсон байн уу үзээд ир” гэж Ананд зандрав. Ёндонжамц нар гэрээс гарч ирээд учрыг сайн ойлгохгүй сандарч “хэн орсон гэж?” гээд гайхан зогсоно. Луухааныг гэрээс чирч гаргаж ирэхэд луухаан “Амь авар, би ямар ч буруугүй” гэж амь гуйн сөгдөх үед Ананд гарт барьсан буугаа түүн рүү чиглүүлэн онилов. Хашаанд байсан хүмүүс болон Ёндонжамц “Та чинь яах нь вэ гэмгүй амьтныг” гэж хэлэх зуурт бууны онилсон зүгт гүйж буй охиныхоо араас “Миний хүү, Амарзаяа аа” гэж хаширч дуусаагүй яг тэр агшинд буун дуу гарч гуйн очсон Амарзаяа луухааны урдуур нь орж буудуулан унав. Аав нь “Ээ, юу болох нь энэ вэ, миний охин, миний хүү” гэсээр ухасхийн очиж Амарзаяаг түшиж авав. Ананд балмагдан ийш тийш хараад бусад нь гарч явсан тул араас нь даган гарч давхив. Хашаанд байсан хүмүүс хэсэг зуур балмагдалын байдалд байснаа сандран үхэтхийн унасан Амарзаяагийн хажууд гүйлдэн ирцгээж тойрон авцгаав. “Төрийн сүлд өршөө” УСК-ны 5-р бүлгийн хэсгээс...

Дөрөв. Дүгнэлт

Зохиолч Д.Намдаг нь Д.Пагмадулам болон бусад хамт хэлмэгдсэн хүмүүсийн тухай ярьж хэлэх хязгаарлагдмал, дарамт шахалттай цаг үед Д.Пагмадуламыг уран сайхны дүрээр бичиж үлдээхийг зорьжээ гэж хэлж болохоор байна. Учир нь Д.Пагмадуламын талаарх дурсамж яриа, бичвэр, тэмдэглэлүүдэд дурдагдаж буй түүний хувь хүний онцлог, авьяас чадвар, хандлага нь уран сайхны дүрийн онцлог шинжтэй ч ижил төстэй байгаа юм. Тухайлбал, ямар нийтлэг тал байгааг авч үзвэл:

Нэгдүгээрт, өссөн газар болон гэр бүлийн тухайд ижил төстэй тал байна. Д.Пагмадулам Наймаа хотын уугуул гэж дурсамж, бичвэрүүдэд олонтаа дурдагдаж байгаа бол уран сайхны дүрийн бүсгүй ч мөн адил Наймаа хотод амьдарч байгаагаар дүрслэгдсэн. Бас Д.Пагмадулам сурвалжит язгууртан гаралтай, чинээлэг айлын охин байсан тухай тэмдэглэгдсэн байсантай ижил уран сайхны дүрийн бүсгүй ч хот хөдөөгийн хооронд панз наймаа хийдэг чинээлэг айлын охин гэдгээр дүрслэгджээ.

Хоёрдугаарт, гадаад үзэмж, биеэ авч явж буй байдал, эрдэм боловсролын талаарх Д.Пагмадуламын шинж төрх нь уран сайхны дүрийн бүсгүйтэй дүйцэж байна. Тодруулбал, Д.Пагмадулам нь сурч мэдсэн эрдэм боловсролоор хамт гадаад улсад суралцаж буй үеийн нөхөд дундаа онцгойрч байгааг, мөн цэвэрхэн цагаан царайтай дэгжин бүсгүй байсан тухай дурсамж

яриа болон бичвэрт тэмдэглэгджээ. Уран сайхны дүрийн бүсгүй ч мөн адил үзэмж гоо, ганган дэгжин бөгөөд намбалаг, дуу хөгжим, бичиг номд мэрийлттэй эрдэм мэдлэгтэй байдлаар дүрслэгдсэн байгаа юм.

